

БНХАУ-ЫН БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ ДЭХ ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРОН

Ч.БАТЦЭЦЭГ*

Манай сэтгүүлийн өмнөх дугаарт Н.Ариунгуа доктор “БНХАУ-ын баруун бүс нутгийн хөгжлийн стратеги” сэдвээр өгүүлэл бичиж уншигч та бүхэнд БНХАУ-ын эдийн засгийн хөгжлийн ололт амжилт, бүсчилсэн хөгжлийн стратеги төлөвлөлтийн тухай ойлголтыг хүргэсэн билээ. Тэгвэл энэ дугаартаа Хятад улсын бүсчилсэн хөгжлийн стратегийн хэрэгжилтийн гурав дахь үе шат болох БНХАУ-ын баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн төсөл Өвөр Монголын Өөртөө Засах Орны эдийн засгийн хөгжилд хэрхэн тусгалаа олж буй талаар өгүүлэх болно.

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэл нээлттэй бодлого явуулж эхэлснээс хойш хориод жилийн дотор Өвөр Монголын Өөртөө Засах Орон (ӨМӨЗО) нь харьцангуй хөгжиж ирсэн боловч зах хязгаарын нутаг болохоор зам тээвэр, харилцаа холбоо, мэдээлэл муутай, хот хөдөөгийн дэд бүтэц сайн хөгжөөгүй, байгаль экологийн орчин гэмтэж, бохирдсон, байгалийн бэрхшээл ихтэй, хэдийгээр байгалийн баялаг элбэг боловч нээн олдворлох хүчин чадал дутмаг, бүс нутгийнхаа давуу байдлыг бүрэн дүүрэн ашиглаж чадаагүйн улмаас эдийн засгийн хөгжлөөр нэлээд хоцрогдонгуй байсан нь энэхүү стратегийн төлөвлөгөөнд багтах гол үндэслэл болсон аж.

Баруун бүс нутгийн хөгжлийн стратегийн төсөлд хамрагдах болсноор ӨМӨЗО нь нийгэм, эдийн засгийнхаа хөгжлийг түргэтгэх, бүс хоорондын хөгжлийн зөрүү, ялгааг багасгах, үндэстнүүдийн эв нэгдлийг бататгах, хил хязгаарын тогтвортой байдлыг бэхжүүлэх үүднээс стратегийн энэ хөтөлбөрт хэрхэн оролцох, эдийн засгийн аль салбарт бүтээн байгуулалтыг голлон хийх, хөрөнгө оруулалтыг хэрхэн үр өгөөжтэй ашиглах

үндсэн чиглэлийг тогтоосон байна. Үндсэн чиглэлд Өвөр Монголынхоо бодит байдлыг харгалзан хөдөө аж ахуй, эрчим хүч, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, харьцангуй давуу байдал, нөөц бололцоогоо чухалчилж Хятадын хойд хэсэгт байгаль экологийн хамгаалалтын хамгийн чухал “Гурван бүс” байгуулахаар болжээ. Энэ нь Өвөр Монголыг Хятадын мал аж ахуй, газар тариалангийн үр өгөөж, байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хөгжлийн чухал бүс; хүнд үйлдвэрийн машин тоног төхөөрөмжийн үйлдвэрийн хөгжлийн бүс; газрын эрдэс баялаг, эрэл хайгуул шинжилгээ-үйлдвэрлэлийг нээх хөгжлийн бүсийн бүтээн байгуулалтын ажил юм.

Байгаль экологийн бүтээн байгуулалт, зам тээврийн сүлжээ, цэвэр усны нөөцийг ашиглах, усжуулалтын систем, хотын дэд бүтцийн шугам сүлжээ, соёл боловсрол, сурган хүмүүжүүлэх ажил, аж ахуйн бүтцэд зохицуулалтын үйл ажиллагааг өөрчлөх, биотехнологи, хөдөө орон нутгийн аялал жуулчлал, малчид тариачдын амьжиргааг дээшлүүлэн чинээлэгжүүлэх, хилийн боомтын бүтээн байгуулалт гэх мэт бүхий л салбарыг хамран “Арван том бүтээн байгуулалт”-ын ажлыг хийхээр төлөвлөсөн байна.

Баруун бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх стратегийн хөтөлбөрийн дагуу ӨМӨЗО-ын төлөвлөсөн ажлын хүрээнд сүүлийн жилүүдэд дотоодын болон гадаадын мэргэжилтэн, боловсон хүчин олноор ирэхийн сац гадаад дотоодын хөрөнгө оруулалт маш ихээр нэмэгдэж, техник тоног төхөөрөмж ихээр нэвтэрлээ. Ингэснээр Өвөр Монголын эдийн засаг ялангуяа 2000 оноос хойш түүхэндээ байгаагүй түргэн хурдацтай хөгжих болов.

*Ч.Батцэцэг. ШУА-ийн ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

Өвөр Монголын эдийн засгийн хөгжлийн гол үндэс суурь мал аж ахуй учир баруун бүсийн стратегийн үндсэн чиглэлд мал аж ахуйг хөгжүүлэх бодлого чухал байр эзэлнэ. ӨМӨЗО-ы бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг нутаг орныг хөгжүүлэх арга зам, хөгжлийн загвар, уламжлалт хэв маягийг шинэчлэх зорилт дэвшүүлэн мал аж ахуйн үйлдвэрлэлийг орчин үеийн техник технологитой хэрхэн холбох, шинжлэх ухааны үндэслэлтэй үр ашгийг дээшлүүлэх, орон нутгийн нийгэм, эдийн засгийн байдал малчин, тариачдын амьжиргааг сайжруулах зэрэг цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон цоо шинэ өөрчлөлт, туршилт хийж байна. Улмаар малчдын аж амьдралыг дээшлүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийг сэргээснээр мал сүргийн бүтцийн чанар сайжирч, бэлчээр-газар ашиглалт, малын тоо толгой, ноос ноолуур, арьс шир, мах, сүү зэрэг бүтээгдэхүүнээрээ улсдаа тэргүүлэх болжээ. Тухайлбал: 2004 оны малын тооллогоор малын нийт тоо толгой 92.74 саяд хүрч 2003 оныхоос 16.1 хувиар өсчээ.

Өвөр Монгол нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээрээ дотоодынхоо хэрэгцээг хангаад зогсохгүй Хятадын бусад муж хотуудад нийлүүлэх болов. Жишээ нь: ӨЗО-ы Хөх хот дахь “Мэнню” (“Монгол үнээ”) сүү сүүн бүтээгдэхүүний корпораци Хятад даяар нэрд гарсан агаад сүүн бүтээгдэхүүний орлого 2004 онд 7.2138 тэрбум юань-д хүрчээ.

Мал аж ахуйгаа эрчимтэй хөгжүүлэхийн тулд нэн тэргүүнд байгаль экологийн нөхцлийг сайжруулахад гол анхаарлаа хандууллаа. Урд өмнө малын тоо толгой нэмэгдсэнээр бэлчээрийн даац хэтрэн цөлжилт үүсч, хөрс эвдэрч гэмтсэн, байгаль орчин бохирдсон гэх мэт ноцтой байдлыг засч залруулахын тулд байгаль экологийг сэргээн засварлах, хамгаалах ажлыг онцолсон байна. Үүнд: газар хагалбарыг зогсоож, мод, өвс тарьж ургуулах, байгаль орчиндоо зохицуулан ард иргэдийг нүүлгэн шилжүүлэх, Хятадын хойд газар нутгийн хамгаалалтын гурван бүсийг ойжуулах, цөлжилтөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, элсний нүүдэл, шар шороон шуургыг зогсоох, Их Хянганы давааны ой шугуйг хамгаалах зэрэг бүтээн байгуулалтын ажлыг эрчимтэй хэрэгжүүлж байна.

Газар тариалангийн талбайг сайжруулан, усжуулалтын тоног төхөөрөмж суурилуулах, усан санг бэхлэх, далан засах, ус ашиглалтын байгууламжид асар их хөрөнгө оруулалт хийснээр чухал ач холбогдолтой болжээ. Үр тарианы нийт хураалт 15 сая тн-д хүрч 10.6 хувь нэмэгдсэн байна.

Баруун бүсийн хөгжлийг эрчимжүүлэх төлөвлөгөөнд автозамыг голлосон дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлж байгаа. Үүний үндсэн дээр сүүлийн жилүүдэд ӨМӨЗО “хөндлөнгийн гурав, гулд ес, арван хоёр гарц” гэсэн автозамын бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөж, нийт 40,8 тэрбум юаний хөрөнгө оруулалт хийж, зүүн баруун чиглэлийн муж хоорондын автозамыг байгуулах томоохон төсөл хэрэгжүүлж, шинээр 11,2 мянган км, нийт 74 мянган км автозамтай, нийт 7475 км төмөр зам ашиглалтанд оруулаад байна.

Өвөр Монголын аж үйлдвэрийн зонхилох салбар уул уурхай, нүүрс, цахилгаан эрчим хүч, мод боловсруулах, барилга, нэхмэл, хүнсний үйлдвэр юм. Үүн дотроо нүүрсний үйлдвэр чухал байр эзэлдэг. Ялангуяа Зүүнгарын нүүрсний уурхайгаас гадна Хятад улсын ил уурхайн дөрөв нь Өвөр Монголын нутаг дэвсгэрт байдаг. Эдгээр уурхайг түшиглэн цахилгаан эрчим хүчний үйлдвэрүүд амжилттай хөгжиж, Бээжин болон бусад газарт нийлүүлдэг бүх Хятадын эрчим хүч, түүхий эдийн чухал бааз болжээ. Аж үйлдвэрийн нэмүү өртөг нь ӨЗО-ны ДНБ-ий 37,5 хувийг эзэлж байна. Жишээ нь Шэньхуа нүүрсний корпорацийн нүүрсийг төс болгох зэрэг томоохон ажлыг эхлүүлж ашиглалтанд оруулаад байна.

Ийнхүү үйлдвэр, аж ахуйн газруудын хэлбэр, бүтэц, зохион байгуулалт улам боловсронгуй болж дотоод гадаадын зах зээл рүү шилжиж байгаагийн сацуу улс даяараа нэрд гарсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай үйлдвэрүүд олноор бий болжээ. Сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн аж ахуй түргэн хөгжиж, эдийн засгийн томоохон корпорациуд байгуулагдаж, ӨЗО-ы эдийн засгийн хөгжилтөнд, ялангуяа гадаад худалдаанд чухал байр эзлэх боллоо. Ажлын байрыг нэмэгдүүлэх, шинээр бий болгох, ажлаар хангах, ажилгүйдлийг багасгах ажлыг эрчимтэй явуулж байна.

Баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн бодлогын тулгамдсан асуудлын нэг бол хятадын хүн амын боловсролын төвшинг дээшлүүлэх, шинжлэх ухаан техникийн хөгжлийг дэлхийн төвшинд ойртуулах, гадаадын шинжлэх ухаан, техник технологи, боловсролын ололтыг чөлөөтэй нэвтрүүлж, түүнд суралцах явдлыг ойрын ирээдүйн гол зорилт болгосон явдал юм.

Нээлттэй бодлого хэрэгжүүлэх үүднээс “Гадаадтай харилцах” стратегийг идэвхжүүлэх, “Хойд зүгт нээлттэй байх”, “Гаднаас оруулж ирэх” гэх зэргээр томъёолон салбар тус бүрд бүтээн байгуулалтын ажлыг хийж байна. 2004 онд Өвөр Монголд дотоодын хөрөнгө оруулалт 70.2 тэрбум юаньд хүрч, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар 600 сая ам доллар оруулжээ.

Гадаад дотоодын хөрөнгө оруулалтаас гадна өөрийн хүчээр бүтээн байгуулалтынхаа

суурийг тавих, шаардлагын дагуу боловсон хүчин, мэргэжилтэн бэлтгэх сургах ажлыг чухалчилж байгаа хэдий ч хөгжлийн явцад оршиж буй дутагдал, бэрхшээлийг даван туулах, төвөгтэй асуудлыг шийдвэрлэх явдал нэлээд байгаа нь зүйн хэрэг. Тухайлбал: мал аж ахуй, газар тариалан эрхэлдэг хөдөө нутагт хөрөнгө оруулалт хангалтгүй, байгалийн баялгаа нээн ашиглах талаар дутмаг, бүс нутаг хоорондын хөгжил харилцан адилгүй, хот хөдөөгийн ард иргэдийн амьжиргааны төвшин, орлого ялгаатай, нийгмийн баталгаа муу г.м.

Хятадын Засгийн газар, орон нутгийн удирдах байгууллагаас дээрхи дутагдлыг арилгахын тулд шат дараалсан арга хэмжээ авч, ард түмнийхээ аж амьдралыг чинээлэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж байна.